



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 04  
№46 (1342)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |      |
|------|--|------|
| 673. | Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай  | 4227 |
| 674. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай | 4229 |





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 32<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### “32<sup>1</sup> дүгээр зүйл.Төсвийн төслийг дахин өргөн мэдүүлж, батлах

32<sup>1</sup>.1.Улсын Их Хурал улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол Засгийн газар холбогдох төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

32<sup>1</sup>.2.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийн танилцуулга, тооцоо, судалгааг энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсөвт үндэслэн боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тусгасан байна.

32<sup>1</sup>.3.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу төсвийн төслийг өргөн мэдүүлэхдээ энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй.

32<sup>1</sup>.4.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу өргөн мэдүүлэх төсвийн төсөлд энэ хуулийн 8.4, 8.5 дахь хэсэг, 28<sup>1</sup> дүгээр зүйл хамаарахгүй.

32<sup>1</sup>.5.Улсын Их Хурал энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**Индригх Фидо - 02 Нөдөл**

Хуульчилсан үндсэн дээр

2024 оны 6 сарын 26 өдөр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр  
Хуульчилсан үндсэн дээр

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх

Хуульчилсан үндсэн дээр болон түүний өмнөх



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮХЭЛД НЬ ТАВЬСАН ХОРИГИЙГ ХҮЛЭЭН АВЧ ХУУЛЬ, ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНТОЙ ХОЛБОГДУУЛАН МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ДЭГИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 32<sup>1</sup> дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1 дэх хэсэгт заасан хугацааг баримтлахгүй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг эцэслэн баталж дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**Мэдээлэл - 02 Хөд**

МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй

2024 оны 11 сарын 15 - өдөр

МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй  
МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй  
МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй  
МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй  
МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй

1. Хүний нөөц...  
2. Өндөр...  
3. Өндөр...  
4. Өндөр...

5. Хүний нөөц...  
6. Өндөр...  
7. Өндөр...  
8. Өндөр...

МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй

МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХуй







**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

**Индекс:** 200003